

ЗАРИМ БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ӨСӨЛТ, ТҮҮНИЙ УЧИР ШАЛТГААН

Судалгааны хэлтсийн эдийн засагч А. Хулан, Ариунхишиг

I. ОРШИЛ

Аливаа орны эдийн засгийн тогтворжилт, хөгжлийг тодорхойлох макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн нэг нь инфляци буюу үнийн өсөлт юм. Манай орны хувьд 2000 оны 12 дугаар сараас эхлэн инфляцийн түвшинг 8 бүлгийн нийт 239 нэр төрлийн бүтээгдэхүүн бүхий хэрэглээний сагсыг үндэслэн тооцож байна. Хэрэглээний бүтээгдэхүүний сагс гэдэг маань жирийн иргэний хэрэглэдэг бараа, үйлчилгээний бүрдэл бөгөөд хэр их хэрэглээтэй бүтээгдэхүүн гэдгээс хамааран хувийн жин нь тодорхойлогддог. Хүнсний бүтээгдэхүүн нь нийт сагсны 49.7 хувь буюу хамгийн их хувийг эзэлдэг бол үүний дараа орон сууц, түлш, цахилгаан (13.1%), хувцас, гутал, бөс бараа (10.1%) ордог байна. Өөрөөр хэлбэл, хүнсний бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл нь инфляцид хамгийн ихээр нөлөөлнө гэсэн үг юм.

Хүснэгт 1. Хэрэглээний барааны сагсан дахь барааны бүлэг, хувийн жин

	Хувийн жин
Хүнсний бараа	0.497
Хувцас, гутал, бөс бараа	0.1065
Орон сууц, түлш, цахилгаан	0.1308
Гэр ахуйн бараа	0.0419
Эм, тариа, эмнэлэгийн үйлчилгээ	0.0187
Тээвэр холбооны үйлчилгээ	0.0846
Соёлын бараа, үйлчилгээ	0.081
Бусад бараа, үйлчилгээ	0.0395

Хүснэгт 2. Хүнсний барааны дэд бүлгийн ангилал, хувийн жин

	Хувийн жин
Гурил, гурилан бүтээгдэхүүн	0.1452
Мах, махан бүтээгдэхүүн	0.1459
Сүү, сүүн бүтээгдэхүүн	0.0452
Сахар, чихэр, цай, жимс	0.0414
Төмс, хүнсний ногоо	0.0484
Хүнсний бусад бараа	0.0294
Архи, ундаа, тамхи	0.0415

Эндээс харахад гурил, гурилан бүтээгдэхүүн болон мах, махан бүтээгдэхүүн нь монгол өрхийн хамгийн чухал хэрэглээ болдог. Ялангуяа төв суурин газруудад амьдардаг өрхүүдийн дийлэнхийн амьжиргаа нь эдгээр бүтээгдэхүүний үнээс ихээхэн хамаардаг гэхэд нэг их хилсдэхгүй л болов уу.

Сүүлийн саруудад хүнсний бүтээгдэхүүн, тэр дундаа мах, гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх онуудаас илүүтэйгээр өсч, зарим бүтээгдэхүүний хувьд ажиглагддаг улирлын чанартай хэлбэлзэл алдагдах хандлагууд гарч байна. Ийнхүү үнэ өсөж байгаагийн учир шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсүүдийг тодруулах зорилготойгоор энэхүү түүвэр судалгааг Монголбанкны Мөнгөний Бодлого Судалгааны Газраас хийв. Судалгааны хүрээнд “Меркури”, “Хүчит шонхор”, “Бөмбөгөр” зэрэг томоохон хүнсний захуудаар явж гурил, гурилан бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, цагаан идээний 30 гаруй борлуулагч нартай уулзаж үнийн өсөлт, үүний учир шалтгааны талаар ярилцлаа. Үнийн өөрчлөлтөд

тухайн бараа бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн өөрчлөлт; орлуулах¹ болон хавсрах² бүтээгдэхүүний үнэ; бараа бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгчид хүргэхэд шаардагдах шатахууны үнэ гэх мэт хүчин зүйлсүүд нөлөөлдөг.

II. ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ


Шатахууны үнийн өсөлт болон хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийн хоорондын уялдааг судлав. 2004 оны 5 сараас 7 сарын эцсийг хүртэлх хугацаанд Аи-76 бензиний үнэ 480 төгрөгөөс 560 төгрөг, Аи-93 500 төгрөгөөс 617 төгрөг, дизель түлш 450 төгрөгөөс 610 төгрөг болтол өссөн байна. 2004 оны 9 сарын 10-ны өдрийн байдлаар Аи-93 675 төгрөг, Аи-95 735 төгрөг, Аи-80 620 төгрөг, дизель түлш 695 төгрөг байв.

Ирак дахь тогтворгүй байдал үргэлжлэн ОХУ-ын нефтийн хамгийн том үйлдвэрлэгч болох Юкос компанийн татварын асуудлаас үүдсэн хямрал зэрэг нь дэлхийн зах зээл дээрх нефтийн үнэ өсөхөд нөлөөлж сүүлийн 60 жилд байгаагүй өндөр түвшинд (1 баррел нь 48 ам.доллар) хүрчээ. Хэдийгээр сүүлийн сард энэхүү үнэ буурч 44 орчим ам.доллар болсон ч энэ нь мөн л сүүлийн 10 жилд байгаагүй өндөр үнэ юм. Мөн нөгөө талаас, манай улс нийт шатахууны бүтээгдэхүүнийхээ 90 хувийг ОХУ-аас оруулж ирдэг гэсэн тоо байдаг. Тус улс нь нефтийн үнийн өсөлтөөс холбоотой гэсэн тайлбартайгаар нефтийн бүтээгдэхүүний экспортын гаалийн татварыг энэ оны бараг сар тутамд тогтмол (6 дугаар сард өөрчлөөгүй) нэмсээр 7, 8 дугаар сард огцом нэмсэн байна. Дээрхи шалтгааны улмаас дотоодын зах зээл дээр шатахууны үнэ мэдэгдэхүйц өсчээ.

III. ҮР ДҮН

Мах, махан бүтээгдэхүүн

Зураг 1. Хонь ба үхрийн махны үнийн өөрчлөлт (төгрөг/кг)



Ер нь өнгөрсөн 2 жилийн хандлагыг ажиглахад 6-7 дугаар саруудад махны үнэ буурдаг байсан. Харин энэ оны тухайд гэвэл өсөлтийн хурдац л ялимгүй багассанаас бус үнэ буурахгүй байна. Махны борлуулагч нарын хэлж байгаагаар үнэ ер нь буурах нөхцөл хангалттай бүрдэхгүй байна гэгцгээж байлаа. Тэдний яриагаар махны үнэ өсч байгаа хэд хэдэн шалтгаан байгаа бөгөөд хамгийн үндсэн шалтгаанаар нь шатахууны үнийн өсөлт болон Нийслэлийн Засаг Даргын 2003 оны 468 тоот захирамжтай холбоотойгоор авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг дурьдав.

¹ Орлуулах бараа гэж тухайн бүтээгдэхүүний оронд хэрэглэж болох барааг хэлж байна. Жишээлбэл хар цайны үнэ өсөхөд түүний оронд сүүтэй цай орлуулж хэрэглэж болох юм.

² Хавсрах бараа гэж тухайн бүтээгдэхүүнтэй хамт хэрэглэгддэг барааг хэлнэ. Жишээлбэл ногоон цай, сүү хоёрыг хамт хэрэглэдэг. Аль нэгнийх нь хэрэглээ багасахад нөгөөгийг нь хэрэглээ ч багасдаг.

Шатахууны үнийн өсөлтөөс үүдэн тээвэрлэлтийн зардал өсөж, энэ нь бараа бүтээгдэхүүний үнэ өсөх нэгэн шалтгаан болдог. Махны хувьд ч энэ нь мөн адил. Харин шатахууны үнийн өсөлтөөс илүүтэй нөлөөлөл үзүүлж байгаа нь дээр дурьдсан захирамж юм. Нийслэлд мал аж ахуй эрхлэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах, худалдах явдлыг эмх цэгцтэй болгох, хүн, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн Газрын 133 дугаар тогтоол 2002 оны 7 сарын 1-ний өдөр гарсантай холбогдуулан 2003 оны 11 сарын 6-ны өдөр Нийслэлийн Засаг Даргын 468 тоот захирамж гарсан байна. Энэхүү захирамжийн дагуу хотын баруун, зүүн хоёр захад буюу зөвхөн Эмээлт, Цайз захуудад л түүхий эд хүлээн авах, борлуулах, хадгалах үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрчээ.

Урьд нь малчид өөрсдөө махаа бэлтгэж, хүнсний захууд дээр авчирч зардаг эсвэл хотын дотор байрлах “Хүчит шонхор” хүнсний зах дээр мах бэлтгэлийг хийж хүнсний захын махны худалдагч нарт нийлүүлдэг байсан бол энэхүү захирамж гарснаар энэ нь боломжгүй болсон. Ихэнх тохиолдолд ченжүүд өөрсдөө хөдөө явж махаа авчран хотын гадна байрлах зөвшөөрөгдсөн цэгүүдэд махаа бэлтгүүлэн, тэндээсээ хот руу оруулж ирдэг болсон байна. Ийнхүү явах боломж тэр бүр байдаггүйгээс нийлүүлэлт тодорхой түвшинд багасаж үнэ өсөх нэгэн шалтгаан байж болно. Мөн махыг ингэж бэлтгэх нь тээвэрлэлтийн зардлыг нэмэгдүүлдэг нь ойлгомжтой. Учир нь хөдөө орон нутаг руу явж мах бэлтгэдэг ченжүүд ихэвчлэн том тэрэг хөлсөлж явдаг бөгөөд Хөдөө-Хот гэсэн дан маршрутын оронд Хөдөө-Эмээлт/Цайз-Хот гэсэн давхар маршруттай болсноор машин хөлслөх үнэ, шатахуун гэх мэтээр үнэ нь өснө. Тээвэрлэлтийн зардлаас гадна хадгалалт, хөргөлтийн зардал нэмэгдэж байгаа, зуны халуунд хадгалах боломж тааруугаас махыг бага багаар нь тэр холоос зөөх хэрэгтэй болж байгаагаас үнэ бас өсөж байна гэж борлуулагч нар хэлж байлаа.


Улаанбаатар хот шиг төвлөрсөн суурин газар малын гаралтай гоц халдварт өвчин гарвал ямархуу хурдан тархаж, ямар хор хөнөөл учруулж болох нь тодорхой. Өнгөрсөн борооны хойноос цув нөмрөв гэгч болохгүйн тулд шаардлагатай арга хэмжээг авах нь зайлшгүй юм. Одоохондоо мах, түүхий эдийг дээрх замаар бэлтгэн, нийлүүлж, борлуулах нь шинэ зүйл бөгөөд борлуулагч нарын хувьд хэвшмэл болох хангалттай хугацаа өнгөрөөгүй байна. Ямартаа ч шинэлэг зүйлээс үүдсэн цочрол намжаад, хүмүүс дасан зохицоод ирэхэд байдал хэвийн болох нөхцөл бүрдэх юм. Зарим иргэдийн хэлж байгаагаар хэдий энэхүү захирамж гарсанаар эрүүл ахуйн шаардлага өндөрсөж, гоц халдварт өвчнөөс сэргийлэх боломж сайжрах ёстой боловч, иргэд хулгайгаар хашаандаа, ямар ч шаардлага хангаагүй орчинд мах бэлтгэж, гэдэс дотрыг нь ил хаяж байгаа нь зарим талаараа бүр ч аюултай байж болох юм.

Үүнээс гадна сүүлийн хэдэн жилийн ган, зудын уршгаар малын тоо, толгой ихээр хорогдсон бөгөөд үүнээс үүдэн идшинд хэрэглэх малын тоо багасаж, амьд малын үнэ хөдөө орон нутагт нэмэгдсэн байна. Мөн зарим тохиолдолд хотод махны үнэ нэмэгдэж байгаа сургаар малчид үнээ хөөргөж, зардал, чирэгдэл болж очсон махны ченжүүд тэрхүү үнийг нь хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүйд хүрдэг гэж хэлж байлаа.

Төмс, хүнсний ногоо

Сүүлийн 3 жилийн үзүүлэлтээс харвал 8 сарын эхээс 10 сарын эх хүртэл ногоо хамгийн хямд үедээ байдаг байна. Ингэж үнэ хямдардаг нь 8 сараас ургац гарч нийлүүлэлт огцом өсдөгтэй холбоотой.

Зураг 2. Өргөн хэрэглээний зарим хүнсний ногооны үнэ (төгрөг/кг)



Дээрх зургаас харахад 2004 онд төмс, манжин, луувангийн үнийн түвшин 2003 болон 2002 оныхоос доогуур байгаа бөгөөд харин энэ оны 6 сараас эдгээр ногооны үнэ огцом өссөн харагдаж байна. Харин "Хүчит шонхор", "Бөмбөгөр", "Меркури" хүнсний захуудаар явж судалгаа хийхэд 8 дугаар сарын эхний хагасаас хүнсний ногооны үнэ огцом буурсан байна. Жишээлбэл, 8 дугаар сарын 13-ны өдөр "Хүчит шонхор" зах дээрх монгол төмс (кг) 250 төг, манжин (кг) 400 төг, лууван (кг) 500 төг болсон байна.

Хүнсний ногооны нийлүүлэгчдээс авсан судалгаанаас үзэхэд импортын болон дотоодын нийлүүлэлт эсэхээс шалтгаалж хүнсний ногооны үнэд өөр өөр хүчин зүйлс нөлөөлдөг байна. Бидний хэрэглэдэг жимс жимсгэнэ болон олон төрлийн хүнсний ногоог урд хөршөөс импортоор оруулж ирдэг.


Импортын хүнсний ногооны үнэд нөлөөлдөг гол хүчин зүйлс бол ам. доллар, юаны ханшийн өөрчлөлт, нийлүүлэлтийн хэмжээ, төмөр замын татвар болон гаалийн татварын хэмжээ юм. Сүүлийн саруудад ам. долларын ханш огцом өссөн, түүнийг даган юаны ханш ч өсч байгаа нь ногооны үнэ нэмэгдэхэд нөлөөлж байна. Мөн импортын гаалийн татварыг нэмсэн нь үнийг өсгөх магадлалтай хэдий ч одоогийн байдлаар гаалийн татвар нэмэгдэхээс өмнө оруулж ирсэн ногоогоо зарж байгаа тул гаалийн татварын өсөлт хүнсний ногооны үнэд нөлөөлөөгүй гэж нийлүүлэгчид ярилаа. Үүний мөрөөр Гаалийн Ерөнхий Газраас утсаар лавлагаа авахад ойрын үед гаалийн татварт онцын өөрчлөлт гараагүй гэж бидэнд мэдэгдсэн юм.

Дотоодын ургацын ногооны үнэд нөлөөлөх гол хүчин зүйлүүд бол импортын ногооны үнэ, ургацын хэмжээ болон шатахууны үнэ юм. Монгол ногооны үнийн түвшин гол нь импортын ногооны үнийг дагаж тогтдог бол шатахууны үнээс шалтгаалж бага зэрэг хэлбэлздэг гэж нийлүүлэгчид ярьж байлаа.

Анхан шатны нийлүүлэгчид үнээ нэмсэн ч эцсийн шатны борлуулагчид үнээ аль болох тогтмол байлгах шаардлагаар өөрсдийн ашгийг багасгаж, үнийн огцом хэлбэлзлийг багасгах үйлдэл хийдэг гэж судалгаанд хамрагдсан борлуулагчид бидэнд ярьсан юм. Учир нь үнэ огцом өсөхөд хэрэглэгчид уг барааны хэрэглээг ихээр багасгаж борлуулагчид алдагдалд ороход хүрдэг байна.

Гурил, гурилан бүтээгдэхүүн

Зураг 3. Гурилын үнэ (төгрөг/кг)



Үндэсний Статистикийн Газрын ирүүлсэн үнийн мэдээгээр 2004 онд дээд гурил, 1-р ба 2-р гурилын үнүүд 2002 болон 2003 оны төвшингөөс эрс өссөн байна. Мөн 2004 онд дээд болон 1-р гурилын үнэ оны эхнээс бага зэрэг өссөн байгаа ба 2-р гурилын үнэ огцом өссөн байгааг харж дээрх зурагаас харж болно. Гурилын үнэд улаан буудайн үнэ, үйлдвэрлэл явуулах зардал буюу цахилгаан

эрчим хүч болон шатахууны үнэ нөлөөлдөг. 2004 онд гурилын үнэ урьд хоёр жилийнхээс огцом өндөр байгааг нийлүүлэгчид өнгөрсөн жил Европын орнуудад хэт халж ган болсноос уг орнуудын улаан буудайн ургац багасч бидний гол нийлүүлэгч болох хойд, урд хөршүүд маань гурилаа Европ руу гарган, Монголд нийлүүлэх гурил багассантай холбож тайлбарлаж байна. Хойд болон урд хөршөөс импортлож оруулж ирсэн гурил, мөн дотоодын үйлдвэрийн гурил ижил хэмжээгээр худалдаанд гардаг гэж нийлүүлэгчид хэлж байна. Үнэхээр л Дэлхийн Банкнаас 2004 оны 8 сард гаргасан мэдээгээр 2004 онд дэлхийн зах зээл дээрх улаан буудайны жилийн дундаж үнэ 2003 ба 2002 оны дундажтай харьцуулахад үнийн өсөлт нь эрс их байна. (Хүснэгт 3.)

Хүснэгт 3. Дэлхийн зах зээл дээрх улаан буудайн жилийн дундаж үнэ болон үнийн өсөлт. (ам. доллар / тонн)


Улаан буудайн төрөл	2002	2003	2004	2003/2002	2004/2003	2004/2002
Канад улаан буудай	175.8	177.4	185.8	0.9%	4.7%	5.7%
Америк улаан буудай (хатуу)	148.1	146.1	161.4	-1.4%	10.5%	9.0%
Америк улаан буудай (зөөлөн)	130.0	138.6	149.2	6.6%	7.6%	14.8%

Гурилан бүтээгдэхүүний сүүлийн үеийн үнийн өсөлтөд харин цахилгаан эрчим хүч, дулаан болон шатахууны үнийн өсөлтүүд нөлөөлдөг.

Цагаан будааны үнийн хувьд 2002 оны 7 дугаар сарыг эс тооцвол сүүлийн 2 жилийн хугацаанд тогтмол байж, 2004 оны 3 дугаар сараас бага багаар, 6 дугаар сараас огцом өссөн байна.

Зураг 3.

Цагаан будааны үнэ. (төгрөгөөр)



Гурилын нэгэн адилаар Европын орнуудад ган болж ургац татарснаас урд болон хойд хоёр хөрш маань цагаан будаагаа Европын орнууд руу гаргаж Монгол руу нийлүүлэх нийлүүлэлтээ эрс багасгасантай дээрх үнийн өсөлт холбоотой гэж нийлүүлэгчид ярилаа. Цагаан будаа нь монгол улсын хувьд 100 хувь импортын бараа учраас үнэ нь дотоодын хүчин зүйлээс илүүтэй дэлхийн үнийн жишгийг дагадаг. Дэлхийн банкны

2004 оны 8 сард гаргасан судалгаанаас³ үзэхэд цагаан будааны дэлхийн зах зээл дээрх 2004 оны жилийн дундаж үнэ өмнөх онуудтай харьцуулахад огцом өссөн байна. (Хүснэгт 4.)


Хүснэгт 4. Цагаан будааны дэлхийн зах зээл дээрх жилийн дундаж үнэ (ам.доллар/тонн)

Будааны төрөл	2002	2003	2004	2003/2002%	2004/2003%	2004/2002%
Тайланд будаа, 5%	191.9	197.6	228.0	3.0%	15.4%	18.8%
Тайланд будаа, 25%	175.0	181.7	216.5	3.8%	19.2%	23.7%
Тайланд будаа, 35%	170.5	178.1	213.6	4.5%	19.9%	25.3%

Сүү, сүүн бүтээгдэхүүн

Сүү болон сүүн бүтээгдэхүүн жилээс жилд зуны улиралд огцом хямдардаг ба энэ жил ч энэ хандлага өөрчлөгдөөгүй явагдаж байна. (Зураг 4.)

Зураг 4. Сүүний үнэ. (төгрөг/л)



Сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэгчдээс авсан судалгаанаас үзвэл цагаан идээний улирлын чанартай хэлбэлзлээс бусад үнийн хэлбэлзэл нь шатахууны үнэ болон инфляцын түвшингээс хамаардаг байна. Шатахууны үнэ үргэлжлэн өсвөл сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэгчид үнээ өсгөхөөс өөр аргагүйд хүрнэ гэж борлуулагчид ярив.

IV. ДҮГНЭЛТ

Бидний хийсэн судалгаанаас үзэхэд мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлтөд нөлөөлж байгаа нь хотын гадна буюу Эмээлт ба Цайз захуудад мах бэлтгэх ажлыг

³ Development Prospect group. (2004). *Commodity Price Data*. <http://www.worldbank.org/prospects/pinksheets/pink0204.htm>

төвлөрүүлсэнтэй холбогдон гарч буй тээврийн болон бусад зардалууд, байгалийн гамшгаар малын тоо толгой багассан хүчин зүйлүүд юм.

Сүү, сүүн бүтээгдэхүүн, талх, бусад гурилан бүтээгдэхүүн гэх мэт үндэсний үйлдвэрийн хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт дотоод дахь цахилгаан эрчим хүч, дулаан болон тээврийн зардал буюу шатахууны үнийн өсөлтөөс шалтгаалж байна.

Харин дэлхийн хэмжээнд улаан буудайн нийлүүлэлт болон үнэ өсч байгааг даган монгол дахь гурилын үнэ өсч байна. Түүнчлэн дэлхийн цагаан будааны үнийн өсөлт монгол дахь цагаан будааны үнийн өсөлтийн шалтгаан болж байгаа юм.

Хүнсний ногооны үнийн түвшингийн өсөлтөд нөлөөлж буй гол хүчин зүйл бол доллар, юаны ханш, тээврийн зардал болон импортын гаалийн татварын хэмжээ болох нь харагдаж байна. Ер нь импортын хүнсний бараанд шатахууны үнэ шууд нөлөөлдөггүй бөгөөд түүнээс илүүтэйгээр уг бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хэмжээ, ам.доллар, юаны ханш, тээврийн зардал буюу төмөр замын татвар, гаалийн татвар зэрэг нь үнийг хэлбэлзүүлэх гол хүчин зүйл болж байна.

Ингээд харахад шатахууны үнийн өсөлт өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний үнэд шууд нөлөөлөх нь бидний төсөөлж байснаас бага мэт боловч дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн хөөрөгдөл нь ам. долларын ханшийг өсгөн, түүнчлэн нүүрсний үнийг өсгөх замаар цахилгаан, дулааны үнийг хөөрөгдөх замаар үнэ нэмэгдэх томоохон хүчин зүйл болж байгаа нь дамжиггүй.

Тэгвэл газрын тосны үнийн энэ огцом хөөрөгдөлтийн үр дагавараас сэргийлэх Төв Банкны бодлого юу байх вэ? Эдийн засгийн хүчин чадал болон бусад хүчин зүйлсүүдээс шалтгаалан улс орнуудын боломж, авах арга хэмжээ өөр өөр байдаг. Харин Төв Банкны хувьд гадны нийлүүлэлтийн шокоос хамгаалах чадвар хомс, ер нь байхгүй гэж хэлж болно.